Замын зурвас хэсэг нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд орших бөгөөд ус зүйн хувьд дунд зэрэг хөгжсөн нутагт хамаарна. Энэ районд Бодончийн гол, Төгрөг гол, Ботгоны гол, Хөндлөнгийн гол, Хөндийн гол, Нарийн гол, Цагдуулын гол, Их асгатын гол, Хужиртын гол, Улаан давааны гол, Бураатын гол, Баянбулаг, Хар чулуутын гол, Дансатын гол, Уртын гол, Тавтын сайр, Олон булгийн ам, Ганц модны гол, Сүүжийн гол, Цагаан бургасын гол, Талын толгойн сайр зэрэг 20 гаруй жижиг голууд байна. Бороо хуртай үед болон хаврын шар усны үер болох үеэр уулнаас эх авсан бүх том жижиг голуудын урсгал ихэсч, усны түвшин богино хугацаанд нэмэгдэнэ. Авто замын баруун хэсгээр байрлах өндөр болон бэсрэг өндөртэй уул толгодын жижиг хөндий нь том жижиг гуу жалгуудаар хэрчигдсэн учир хаврын шар усны үеэр болон бороо хуртай зун намрын саруудад гадаргуугийн угаагдал үүсч, уулын ам хөндийгээр садраа үүсгэдэг. Бага Улаан Даваанаас Алтай сумын төв хүртэл 90 км үргэлжлэх Бодончийн хавцал дундуур Бодончийн гол урсах бөгөөд энэ гол нь төслийн хувьд байгаль орчны хамгийн эмзэг бүрэлдэхүүн хэсэгт тооцогдоно.

Зураг 4: Бодончийн хавцал дундуур урсах Бодончийн гол



Газрын гадарга

Ховд хотын төвөөс Манхан сумын төв хүртэл алсуур өгсүүр бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1400-1650м байна. Манхан сумаас Шар хөвийн дөрвөлж хүртэл гүвээрхэг гадаргаар явж Булангийн овоо хүртэл аажмаар уруудна. Булангийн овооноос Манханы хүрэн талаар явж Ботгоны хавцлын ам хүртэл 2-3км-ийн хэрчигдлийн шигүүтэй, бартаа багатай гадарга үргэлжилнэ. Ботгоны амнаас Согоотын хөтөл хүртэл 1600-1940м-ийн үнэмлэхүй өндөр бүхий бартаатай нарийн хавцал хөндий зонхилдог. Согоотын хөтлөөс Тавтын хөндий тал уруудаж Бага Улаан даваа хүртэл 8-12⁰ налуутай 1940-2600м үнэмлэхүй өндөртэй дунд зэргийн бартаатай замаар явна. Бага Улаан даваанаас Баянзүрх хүртэл үнэмлэхүй өндөр огцом буурч 1900м хүрнэ. Баянзүрхээс Бодонч голын хөндий уруудан Боомын ам буюу Алтай сумын төв хүртэл голын хөндий уруудсан ганга, гуу жалга бүхий шигүү хэрчигдэлтэй байна. Өлгий хотоос газрын гадарга ерөнхийдөө өгсөж өндөрсдөг боловч Толбо сумын төв хүртэл гадарга нь тэгш тавцан, зоо бүхий байна. Толбо сумын төвөөс Толбо нуурын уулс хоорондын хотгорт шилжих тул гадаргуу налуу 12-8⁰-аас 8-6⁰ болж хэрчигдлийн шигүү 1-2км болно. Толбо нуурын төвөөс Бураатын даваа хүртэл газрын

гадарга өндөрсөж Хашаатын даваа хүртэл 6-12⁰ налуутай 0,5-1км-ийн хэрчигдлийн шигүүтэй болно. Хашаатын даваанаас Баян энгэр хүртэл газрын гадарга налуу хоолой хэлбэрийн хотгороос голын хөндийд шилжинэ. Баян энгэрээс Хонгиогын ам хүртэл Хонгио голын 1-1,5км өргөнтэй тэвшин хэлбэрийн хөндийг уруудна. Үүнээс Ховд хот хүртэл ухаа гүвээрхэг буюу тэгшивтэр талархаг гадарга зонхилно.

Хөрсөн бүрхэвч

Замын зам дагуух бүсийн нутаг нь Монгол Алтайн уулс, Алтайн өвөр говь, Хар ус нуурын хотгор орчмын багавтар газар говь цөлөрхөг нутагт хамаарна. Нам хотгор газраар говийн цайвар бор, говийн бор, цайвар хүрэн, хүрэн хөрс, голын татмаар аллювийн нугийн, аллювийн ширэгт хөрстэй, уулархаг газраар уулын хүрэн, уулын нугын, уулын нугат хээрийн, өндөр уулын хээрийн бүдүүн ялзмагт хөрс, өндөр уулын нам хотгор газраар нугын цэвдэгт болон нуга намгийн цэвдэгт хөрс зонхилно. Хөрсний ялзмаг агууламж бага дунджаар 0,5-1,5%, хөнгөн шавранцар, шавранцар хөрс тархана. Өндөр уулархаг газраар хөрсний органикийн агууламж ихэснэ. Ихэнх хөрс нь өнгөнөөс эхлэн карбонаттай, зүсэлтийн доод хэсэгт карбонатын агууламж ихсэж 3-8% хүрнэ.

Замын маршрутын дагуу олон жилийн цэвдэгт чулуулгийн газарзүйн тархалтын үргэлжилсэн, алаг цоог, ховор алаг цоог, тохиолдлын бүсийг дайран өнгөрнө. Алтайн нурууны өндөрлөг хэсгээр цэвдгийн үргэлжилсэн тархалт замын маршрутын дагуу хязгаарлагдмал тархсан байна. Ховор алаг цоог тархалттай цэвдэг Өлгий орчимд нилээд тархсан бол Ховд хотоос Алтай нурууг давах хүртэл үргэлжилсэн, алаг цоог, ховор алаг цоог, тохиолдлын цэвдэг тархдаг.

Ургамал

Тэмээн хүзүү- Манхан- Ховд- Баян-Өлгий хүртэл нутаг нь Евразийн хээрийн мужийн Монгол Алтайн уулын хээрийн тойрог болон Төв Азийн цөлийн хээрийн мужийн Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн болон Зүүнгарын цөлийн тойргуудыг хамаарна. Замын маршрутын дагуу судалгаагаар ургамалжилтын 9 хэв шинж, 13 дэд хэв шинжид (өндөр уулын тагийн, өндөр уулын нугын, өндөр уулын хүйтэн хээрийн, уулын хээрийн, уулын чулуусаг хээрийн, уулын хуурай хээрийн, нам уулс уулын хаяаны цөлжүү хээрийн, тэгш талын цөлжүү хээрийн, цөлийн хээрийн, хээржүү цөлийн болон татмын нугын) ялгарна. Хээржүү цөл өндөр уулын таг, хээржүү цөл маш ядмаг ургацтай (100-130 кг/га), уулын хээр цөлжүү хээр харьцангуй түүнээс дээр ургацтай бол гол нуурын эргийн ширэгтэй, нуга намгийн бэлчээр 400-700 кг/га хүрч байна.

Замын маршрутын дагуу 45 овогт хамаарах 234 зүйлийн цэцэгт дээд ургамал бүртгэгдсэн. Амьдралын хэлбэрээр нь үзвэл 1 зүйл мод, 7 зүйл сөөг, сөөгөнцөр, 12 зүйл заримдаг сөөг, заримдаг сөөгөнцөр, 114 зүйл өвслөг ургамал ургадаг. Нийт ургамлын 17 зүйл нь эмийн, 42 зүйл нь бэлчээр тэжээлийн, 8-н зүйл нь хүнсний зориулалтаар ашиглагддаг.

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Амьтны аймаг

Авто замын маршрутын дагуух бүс нутагт 4 анги, 22 баг, 46 овогт хамаарах 142 зүйл сээр нуруутан амьтан бүртгэгдсэн. Үүнээс:

- 6-д баг 13 овогт хамаарах 34 зүйл хөхтөн
- 13-д баг 26 овогт хамаарах 99 зүйл шувуу
- 1 баг 5 овогт хамаарах 7 зүйл мөлхөгч
- 2 баг 2 овогт хамаарах 2 зүйл загас байна.

Шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 55,5% нь бор шувууны багийн шувууд, 13,3% нь шонхор хэлбэртний багийн шувууд байна. Хөхтөн амьтдын дотор зүйлийн тоогоор мэрэгчид 32,3%, махчин 29,4% эзэлж байна. Эдгээрээс агнуурын ач холбогдол бүхий 17 зүйл хөхтөн байна. Тухайн бүс нутагт Монгол улсын болон олон улсын хэмжээнд ямар нэг байдлаар эрх зүйн хамгаалалтад 22 зүйлийн амьтад байгаагаас нэн ховор болон ховор Алтайн аргаль *Ovis ammon*, Янгир ямаа *Capra sibirica*, Ирвэс *Uncia uncia* болон шилүүс *Felis lynx* нутагладаг.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ БА МЕНЕЖМЕНТ

2.1 Байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүрэг, хариуцлага

Баруун Бүсийн Босоо Тэнхлэгийн Авто Замын Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Эко-Алтай” ХХК хийж гүйцэтгэн 2009 онд БОНХЯ-аар батлуулсан юм. Уг үнэлгээний тайланд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан тусгаж өгсөн.

Байгаль орчныг хамгаалах хуулийн дагуу, Төсөл хэрэгжүүлэгч тал Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, БОННУ-нд заагдсан нөлөөллийг бууруулах шаардлага, заавруудыг үйл ажиллагаандаа тусган мөрдөх ёстой байдаг.

Баруун Бүсийн Босоо Тэнхлэгийн Авто Замын Төслийн хувьд төслийн Гүйцэтгэгч тал нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээн ажиллаж буй бол Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хувьд БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Төслийн Гүйцэтгэгч байгууллага нь жил бүрийн байгаль орчны

мониторингийн ажлуудыг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн гүйцэтгүүлдэг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын болон талбайн хяналтын зардал төсвүүд нь Гүйцэтгэгч талтай байгуулсан гэрээнд тусгагдаж өгсөн юм.

БОМТ-ний хүрээнд төлөвлөгдсөн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд нь Замын инженерийн зураг төсөл, Зам барилгын ажлын төлөвлөгөө болон Гүйцэтгэгч талтай хийх гэрээнд тусгагдаж өгсөн бөгөөд зам барилгын ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалалтай холбоотой заалтууд Замын Хяналтын болон Хөдөлмөрийн гэрээнүүдэд тусгагдсан. Дээрх төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зам барилгын ажил идэвхтэй явагдаж буй дулааны улиралд орон нутгийн ард иргэдэд төслийн явцын талаар мэдээлж, саналыг нь тусган авч байх үүргийг Төслийн зүгээс мөн хүлээж буй юм.

Байгаль орчны Багц хуулиуд 2014 оны 5-р сард УИХ-аар шинэчлэн батлагдсан бөгөөд уг хуульд мэргэжлийн хяналтын байцаагчдын ажлын статус, байгаль орчны аудитийг бий болгох зэрэг тодорхой өөрчлөлтүүд тусгагдаж өгсөн. Байгаль орчны шинэчилсэн багц хуулиудад Төслийн ажилд нөлөөлөл үзүүлэхүйц өөрчлөлтүүд гараагүй болно.

2.2 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөий зорилго:

1. Гүйцэтгэлийн гэрээнд заагдсан байгаль орчны шаардлагуудыг хангалттай хэмжээнд биелүүлэх
2. Зам барилгын болон бусад туслах үйл ажиллагаануудыг Байгаль орчны болон бусад холбогдох хууль, дүрэм, журмуудын хүрээнд явуулах
3. Зам барилгын ажлыг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага хэмжээнд байхаар тооцоолон гүйцэтгэх.
4. Байгаль орчны үнэлгээнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
5. Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх Ажлын Төлөвлөгөө боловсруулах
6. Зам барилгын ажилчдыг барилгын үйл ажиллагаатай холбоотой үүдэн гарч болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажлын байрны нөхцөлийг хангалттай хэмжээнд бүрдүүлж өгөх

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

7. Барилгын ажлаас үүдэн гарч болзошгүй аливаа бохирдол, доройтлыг бууруулж, зам дагуу оршин суугаа нутгийн ард иргэдийн эрх ашгийг хамгаалах
8. Монгол Улсын байгаль орчныг хамгаалах хууль болон бусад дүрэм журмуудыг инженер, техникийн ажилтнууддаа чанд мөрдүүлэн ажиллуулж, Төслийг аюул осол, эрсдэлгүйгээр амжилттай дуусгах

2.3 Байгаль орчны гол нөлөөллүүд

Зам барилгын ажлын явцад байгаль орчны дараах нөлөөллүүд үүсэх магадлалтай:

1. Зам дагууах гол горхин дээгүүр гүүр барих үед барилгын материал гол руу унах буюу урсч орох, голын ус булингартах зэргээс үүдэн усны чанарт түр хугацааны нөлөөлөл үзүүлнэ.
2. Зам барилгын ажлаас үүдэн тоосжилт бий болно. Тоосжилт нь замын дагуу ойрхон амьдарч буй нутгийн иргэдэд нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм.
3. Орон нутгийн малчид малаа бэлчээрлүүлэх зэргээр замыг хөндлөн гатлах шаардлагууд гарч ирэх бөгөөд үүнд зам барилгын ажил саад учруулах магадлалтай.
4. Төслийн зам дагуух бүс нутаг нь мөнх цэвдэгтэй тул инженерийн нарийн шийдэл шаардах ба уг бүс нутгийн усны нөөцөд нөлөөлөл үзүүлэх магадлалтай.
5. Төслийн зам нь хэд хэдэн цэгээр зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөний маршруттай огтлолцож таарч буй тул нөлөөлөл үүсэх магадлалтай.
6. Зам барилгын ажилчдын кэмп, суурингуудаас гарах хог хаягдлын асуудал
7. Зам барилгын ажилд ашиглагдах хайрга, шороо олборлох зорилгоор зам дагуу олон ухмал, карьеруудыг нээн ашиглана.

Дээр дурдагдсан бүх нөлөөллүүд нь түр зуурын шинж чанартай бөгөөд нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг зохих ёсоор хэрэгжүүлснээр нөлөөллөөс зайсхийх буюу багасгах бүрэн боломжтой юм.

2.4. Байгаль орчны хяналт

Төслийн зам барилгын ажлын хяналтыг хариуцсан КСИ компаний супервайзорууд байгаль орчны дүрэм, журам, стандартуудын биелэлтэд өдөр тутам хяналт тавьдаг. Хавсралт А-д оруулсан Байгаль орчны ажлын биелэлтийг шалгах хуудсууд нь талбайн хяналтын супервайзоруудын хувьд өдөр тутмын ашиглах зүйл нь болдог. Байгаль орчны хяналтын

ажлын нарийвчилсан үр дүнг Хавсралт А-аас харж болох бөгөөд мөн КСИ компаний сар тутам бэлтгэн ирүүлдэг Ажлын тайлангаас үзэж болно.

2.4 Ландшафт, хөрсөн бүрхэвч

Хатуу хучилттай авто зам ашиглалтад орсноор олон салаа шороон зам гарган давхиж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх, хөрс, бэлчээрийн доройтол үүсэх зэрэг асуудлууд бүрэн шийдвэрлэгдэнэ.

Төслийн зам дагуу идэвхтэй ашиглагдаж буй ухмал, хайрганы карьерын цэгүүд олон байгаа. Тэдгээрийг Төслийн хэсэг тус бүрээр авч үзвэл:

Package1: (Тэмээн Хүзээ-Бага Улаан даваа чиглэлийн 110.8 км замын хэсэг)


Цемент болон асфальтан зуурмагийн хольцод ашиглагдах шигшигдсэн хайрга бэлтгэх 3 хайрганы карьер идэвхтэй ажиллаж байгаа. Тэдгээр нь STA.12, STA.54 ба STA.92 цэгүүд дээр байршиж байна.

Замын далангийн материал бэлтгэх 6 ухмал, туслах материал бэлтгэх 16 ухмал, шигшигдсэн элс бэлтгэх 3 ухмал тус тус ажиллаж байна.

Package 2: (Бага Улаан Даваа-Манхан сум чиглэлийн 103.3 км замын хэсэг)

2013 оны 5 ба 6-р саруудад Манхан болон Мөст сумдын захиргаанаас зөвшөөрөл авсан 24 ухмал идэвхтэй ашиглагдаж байна. Үүнээс барилгын туслах материал бэлтгэх 10 ухмал ашиглагдаж байгаа. Шигшигдсэн элс бэлтгэх 13 ухмал 2014 оны 5-р сараас ашиглагдаж эхэлсэн. Цемент, асфальтан зуурмагийн хольц бэлтгэх зорилго бүхий хайрганы карьер замын STA.54 цэгээс 0,5 км зайд байрлах бөгөөд 2014 оны 4-р сараас ашиглагдаж эхлээд байна.

Зураг 5: Package 1 хэсэгт ашиглагдаж буй замын карьер.



Зураг 6: Package 2 хэсэгт ашиглагдаж буй замын карьер.



2.5 Хог хаягдал

Хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй байдлаар цуглуулах, тээвэрлэх, зайлуулах дараах ажлуудыг Гүйцэтгэгч байгууллагын зүгээс төлөвлөн хэрэгжүүлж байна:


- ❖ Ажилчдын кэмпээс гарч буй ахуйн хог хаягдлыг зөвхөн зориулалтын хогийн цэг рүү зайлуулна.
- ❖ Ажилчдын сууцнаас гарч буй ахуйн хог хаягдлыг кэмп доторх зориулалтын хогийн цэгт цуглуулж шатаах буюу зөвшөөрөгдсөн хогийн цэгт хүргэнэ. Тэдгээр зориулалтын хогийн цэгүүдэд хогийн сав болон хогийн уутыг тавьж байршуулсан бөгөөд байнга соьлж шинэчилж байна.
- ❖ Зам барилгын ажлаас гарч буй хог хаягдлыг холбогдох дүрэм журмын дагуу Замын инженер буюу орон нутгийн захиргаанаас зөвшөөрөгдсөн цэгүүд рүү зайлуулна.

2.6 Усны нөөц

Төслийн зам тавигдаж буй маршрут дагуу Бодончийн гол ба Цахирын гол гэсэн 2 гол урсан өнгөрдөг бөгөөд тэдгээр гол дээгүүр хэд хэдэн цэгт гүүр барихаар төлөвлөсөн байгаа юм.

Бодончийн хавцалд замын даланг зохих ёсоор бат бөх хийхийн тулд Бодончийн голын голдрилыг тодорхой хэсэгт өөрчилж урсгасан. Бодончийн гол нь нутгийн ард иргэдийн амьжиргааны чухал эх үүсвэрүүдийн учраас Гүйцэтгэгч болон түүний инженерүүдийн зүгээс онцгой анхаарал хандуулан хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа юм. Гүйцэтгэгч нь ажилчдын кэмп бүрийнхээ ойр орчимд гүний худаг гарган ашиглаж байна.

Зураг 7: Package 2 хэсгийн Төв кэмнийн ойролцоо урсан өнөгөрх Цахирын гол.



Усны нөөц, чанарыг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн ажлууд:

- ❖ Төслийн Гүйцэтгэгчийн зүгээс гүүрэн гарц баригдаж буй дараах цэгүүдэд гол дээгүүрх хоолойг барьж байгуулсан байгаа: Package 1 -ийн хувьд 1,2,3,4,7-р гүүрүүд, Package2-ийн хувьд STA.54+840 цэгт орших гүүр.
- ❖ Ажилчдын суурингуудаас гарч буй бохир усыг цэвэршүүлэх, зайлуулах төхөөрөмжүүдийг суурилуулсан.
- ❖ Ажилчдын суурингуудад ус зайлуулах сувгуудыг барьж байгуулсан.
- ❖ Зам барилгын ажилчид ундны баталгаат цэвэр усаар хангагдсан. Цэвэр усны хангамжийг кэмпүүдийн ойролцоо гаргасан гүний худгуудаас хийж буй бөгөөд худгийн усны дээжид лабораторийн шинжилгээг тогтмол хийлгэж байгаа.
- ❖ Бетон зуурмаг зөөдөг хүнд даацын машинуудыг гол дээр угаахыг хориглосон.


БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

- ❖ Түлш хадгалах агуулахуудыг бетон хавтангуудаар тусгаарлан хамгаалсан тул түлш, тос зэрэг бодисууд урсаж алдагдах буюу гоожих зэрэг эрсдэлүүд байхгүй болсон.
- ❖ Замын хар тос хадгалах агуулахыг гүний усанд нөлөөлөл үзүүлэх буюу бохирдол үүсгэхээс сайтар сэргийлсэн байгаа.


2.7 Ажилчдын суурингийн тохижилт, ариун цэвэр

- ❖ Үерийн урсацын сувгийг кэмп бүрт хийж өгсөн. Тэдгээр сувгуудыг тогтмол засварлан арчилж байна.
- ❖ Кэмпийн ариун цэврийн өрөөний бохир усыг газар доогуурх шугамаар зайлуулах бөгөөд ариун цэврийн өрөөний гадна талд бохир ус хураах ёмкостиг байрлуулсан.
- ❖ Суурин доторх ажилчдын түр орон сууц болон албан тасалгаануудыг тогтмол цэвэрлэх үүрэг бүхий цэвэрлэгээний ажилчид ажиллуулж байна.

Зураг 8: Package I хэсгийн Төв кэмп дэхь ажилчдын түр орон сууц.



Зураг 9: Package 2 хэсгийн Төв кэмийн гадна орчны тохижилт



- ❖ Ажилчдын суурингуудад гадна талбайн ихэнх хэсгийг цементэлж тоос босохоос сэргийлсэн ба суурин руу орох зам болон үерийн ус зайлуулах сувгийг тогтмол цэвэрлэж арчилдаг.

2.9 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал

ХХАА-ны Төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн:

- ❖ Нийт төслийн хэмжээнд ХХАА хариуцсан Менежер болон Package 1, Package 2 хэсгүүдэд ХХАА хариуцсан инженерүүдийг томилож ажиллуулж байна.
- ❖ Осол аварь гарсан үед яаралтай тусламж үзүүлэх анхан шатны тусламжийн багаж хэрэгслээр тоноглогдсон түргэн тусламжийн машин ажиллаж байна.
- ❖ Осол аюул гарсан үед шуурхай арга хэмжээ авах зорилгоор Осол аюулын менежментийн төлөвлөгөө батлан мөрдөж байна.
- ❖ Аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг барилгын болон кэмийн ажилчдад тогтмол хийж байна.
- ❖ Зам барилгын ажил идэвхтэй явагдаж буй цэгүүд болон бусад газруудад ХХАА-ны уулзалтыг тогтмол хийж хэвшүүлсэн
- ❖ Зориулалтын хантааз, нүдний шил, гутал, малгай, бээлий зэрэг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг ажлын байран дээр өмсөж байх журмыг хэрэгжүүлсэн.

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

- ❖ Ажилчдын суурин, засварын газрууд болон хайрганы карьерууд дээр анхан шатны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг байршуулсан.
- ❖ Замын түр тэмдэг, тэмдэглэгээнүүд босгосон.

ХХАА-ны Менежер дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- ❖ Аюулгүй ажиллагаанд хяналт тавих системийг бий болгож мөрдүүлэх
- ❖ Ажлын баг бүрт ХХАА-ны хянагч нарыг томилон ажиллуулах
- ❖ Ажилчдад ХХАА-ны сургалт хийх
- ❖ Осол аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ХХАА-ны зарчмуудыг тайлбарлан таниулах
- ❖ 7 хоног бүр ХХАА-ны талаарх хурал хийж, ирцийг бүртгэх
- ❖ Ажлын талбар дээрх үзлэг, шалгалтыг байнга хийх
- ❖ Анхан шатны тусламжийн багаж хэрэгслүүд хэрэгцээтэй газартаа бүрэн байгаа эсэхэд хяналт тавих
- ❖ Ажилчид ажилдаа гарахдаа хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээ өмсөж зүүж буй эсэхэд хяналт тавих
- ❖ Ажлын байрны орчин, нөхцөл хэвийн байгаа эсэхэд хяналт тавих
- ❖ Ундны усны чанарт хяналт тавих
- ❖ Машин механизмын техникийн хэвийн байдалд хяналт тавьж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх
- ❖ ДОХ болон БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгож хэрэгжүүлэх
- ❖ Осол аваарийн талаар холбогдох замын инженерүүдэд нэн даруй мэдэгдэх

ХХАА-ны инженерүүд дараах ажлыг гүйцэтгэнэ:

- ❖ Ажлын байрны нөхцөл байдлыг өдөр тутам шалгаж, боломжит эрсдэлийг олж тодорхойлох
- ❖ ХХАА-ны журмын дагуу ажлын байрны аюулгүй байдлын шалгалт хийж, сайжруулах арга хэмжээ авах
- ❖ Ажилчдыг ажлын талбарт гарахын өмнө хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг нь шалгах
- ❖ Хүн даацын машин механизмын бүрэн бүтэн байдлыг шалгаж, болзошгүй осол аваариас урьдчилан сэргийлэх
- ❖ ХХАА-ны шалгах хуудсыг өдөр тутмын үзлэг хийн бөглөх

- ❖ Осол аваарь гарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдал илэрвэл нэн даруй талбайн удирдлагуудад мэдээлж, арга хэмжээ авах

2.10 Дуу чимээ

Машин механизмуудад холбогдох тохиргоо, засварыг хийх замаар барилгын ажил идэвхтэй явагдаж буй цэгүүд дээрх дуу чимээний түвшнийг багасгах арга хэмжээг авсан. Дуу чимээний түвшнийг багасгах талаар хийгдсэн ажлууд:

- 1) Хүнд даацын машин, тоног төхөөрөмжүүдээс гарч буй дуу чимээний нөлөөллийг багасгах үүднээс зам барилгын ажил идэвхтэй явагдаж буй цэгүүд дээр ажиллаж буй ажилчдад зориулалтын чихэвч өмсөх шаардлага тавьдаг. Энэ шаардлага нэн ялангуяа компрессор болон бутлагч машин механизмуудтай ойр ажилладаг ажилчдад тавигддаг.
- 2) Хүнд даацын машин, тоног төхөөрөмжүүдийн ойр орчимд дуу чимээний мониторинг хэмжилтийг тогтмол хийж, дуу чимээ багасгагч аппарат болон зориулалтын чихэвч хэрэглэж буй эсэхийг тогтмол үзэж шалгадаг.
- 3) Одоогийн байдлаар зам барилгын ажлын аль ч хэсэгт 90 децибелээс давсан дуу чимээний түвшин хэмжигдээгүй байна.

2.11 Тоосжилт

Тоосжилтыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.


- ❖ Замын далангийн ажил явагдаж буй хэсгүүдэд зориулалтын ус шүршигч машин ажиллуулах
- ❖ Кэмп, ажилчдын суурингуудын ойр орчимд зориулалтын ус шүршигч машин ажиллуулах
- ❖ Орон нутгийн иргэд зорчин явах үед болон олон салаа шороон замуудаас үүсэх тоосжилт – Гүйцэтгэгчийн хувьд орон нутгийн иргэдийн зорчих хөдөлгөөнийг хянах боломж байхгүй тул зөвхөн зам барилгын ажил явагдаж буй болон хүнд даацын машинууд зорчиж буй хэсгүүд рүү ус шүрших зориулалтын машинуудыг илгээх боломжтой юм.
- ❖ Бутлуурын цех – Package1-ийн Бутлуурын цехэд ажил явагдаж буй үед ус хадгалах ёмкосттой холбосон шлангаар ус шүршиж тоосжилтыг дардаг. Package 2-ийн

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Бутлуурын цех ашиглалтад ороогүй байгаа.

- ❖ Зуурмагийн цех - Package1-ийн Зуурмагийн цех нь тоос шүүдэг төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд хэвийн ажиллаж байгаа. Package 2-ийн Зуурмагийн цех ашиглалтад ороогүй байгаа.

Зураг 10: Бодончийн хавцалд ажиллаж буй ус шүршигч машин



3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ

3.1. Аргазүй

Зам барилгын ажлаас үүдэн гарах сөрөг нөлөөллүүдийг хянаж, зохих хэмжээнд нь барьж байх нь Төслийн хувьд маш чухал асуудал бөгөөд Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр нь төслийн сөрөг нөлөөллүүдийг хянаж бууруулах, барилгын ажилчдын болон зам дагуу оршин суугаа орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн юм. ОХШХ-ийн биелэлтийг хангах зорилгоор Гүйцэтгэгч байгууллагын зүгээс Package 1 ба Package 2 хэсгүүдэд байгаль орчин хариуцсан ажилтнуудыг томилон ажиллуулж байна.


Төслийн Гүйцэтгэгч тал нь орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулсны үндсэн дээр хөрс, ус, агаарын чанарын мониторинг хэмжилтүүдийг 2014 оны ОХШХ-т заасан графикийн дагуу гүйцэтгүүлсэн. Уур амьсгалын нөхцөл байдлаас шалтгаалан Монгол оронд зам барилгын ажил явагдах хугацаа харьцангуй богино байдгийг харгалзан

үзсэний үндсэн дээр Төсөл Хэрэгжүүлэх Нэгжийн зүгээс мониторинг хэмжилт хийх хугацааны давтамжийг сард 1 удаа байхаар тогтоож өгсөн. Мониторинг хэмжилтийн бүх ажлуудыг Монгол Улсын холбогдох арга аргачлал, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Мониторингийн баг нь байгаль орчны нөлөөлөлд хамгийн мэдрэг цэгүүд болох ухмал, карьерууд, ажилчдын суурин, зуурмагийн цехүүд болон Бодонч голын эрэг дагуух газруудыг мониторингийн цэг болгон сонгож авсан бөгөөд Package 1-ийн хувьд 10, Package 2-ийн хувьд 7 мониторингийн цэг тус тус сонгогдсон байна.


Мониторингийн баг нь сонгож авсан мониторингийн цэгүүдэд тоосжилт, дуу чимээний хэмжилт хийж, хөрс, усны дээж аван мэргэжлийн лабораторид шинжлүүлсэн. Ховд аймгийн Ус цаг уурын хүрээлэнгийн мэргэжилтнүүд Dust Trak ба VoltCraft брэндийн тоног төхөөрөмжүүдийг ашиглан тоос, дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн бол Газарзүйн Хүрээлэнгийн мэргэжилтнүүд хөрс, усны дээжүүдийг авч мэргэжлийн лабораторид химийн болон хүнд металлын шинжилгээ хийсэн юм.

Зураг 11: Дуу чимээний хэмжилт хийхэд ашигласан багаж



БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Зураг 12: Агаарын чанарын хэмжээг хийхэд ашигласан багаж



3.2 2014 оны Байгаль орчны Мониторингийн ажлын төсөв

Хүснэгт 2: Package 1 хэсгийн 2014 оны Мониторингийн ажлын төсөв.

Мониторингийн үзүүлэлтүүд	Мониторингийн цэгүүд	Давтамж	Зардал (ам.доллар)	Мөрдөгдөх стандартууд
1. Агаарын чанарын мониторинг, тоосжилт (PM10)	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	290\$ x 10 цэгт x 6 удаа = 17,400\$	MNS:4585-98 MNS:3384 MNS:4048 MNS:5885 : 2008
2. Усны чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Худаг, кэмпийн гал тогоо, голын ус зэрэг 10 цэгээс дээж авах	Сар бүр	330\$ x 10 цэгт x 6 удаа = 19,800 \$	MNS: 3934 MNS: 5667
3. Дуу чимээний хэмжилт, децибеллээр хэмжигдсэн хамгийн дээд түвшин	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	50\$ x 10 цэгт x 6 удаа = 3,000 \$	MNS: 0012-1-009:1995

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

4. Ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал ба эрүүл ахуй	Шаардлагатай бүх цэгүүдэд	Сар бүр	6 удаа - 6,000\$	Эрүүл ахуйн шаардлагууд, Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын журам
5. Хөрсний чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	320\$ x 10 цэгт x 6 удаа = 19,200 \$	MNS: 5850:2008
6. Ургамлын мониторинг Төрөл зүйлийн тоо ба нэгж талбай дахь нягтаршил	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	2000\$	Хээрийн судалгааны аргачлал
7. Амьтны мониторинг Төрөл зүйл, тоо толгой бай шилжилт хөдөлгөөн	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	2000\$	Хээрийн судалгааны аргачлал
Бүгд			69,420\$	

Хүснэгт 3: Package 2, SW1-1 хэсгийн 2014 оны Мониторингийн ажлын төсөв

Мониторингийн үзүүлэлтүүд	Мониторингийн цэгүүд	Давтамж	Зардал (ам.доллар)	Мөрдөгдөх стандартууд
1. Агаарын чанарын мониторинг, тоосжилт (PM10)	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	290\$ x 2 цэгтх 6 удаа = 3,480\$	MNS:4585-98 MNS:3384 MNS:4048 MNS:5885 : 2008
2. Усны чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Худаг, кэмпийн гал тогоо, голын ус зэрэг 10 цэгээс дээж авах	Сар бүр	330\$ x 2 цэгт x 6 удаа = 3,960 \$	MNS: 3934 MNS: 5667
3. Дуу чимээний хэмжилт, Децибеллээр хэмжигдсэн хамгийн дээд түвшин	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	50\$ x 2 цэгт x 6 удаа = 600 \$	MNS: 0012-1-009:1995
4. Ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал ба эрүүл ахуй	Шаардлагатай бүх цэгүүдэд	Сар бүр	6 удаа - 1120\$	Эрүүл ахуйн шаардлагууд, Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын журам

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

5. Хөрсний чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	320\$ x 2 цэгт x 6 удаа = 3,840 \$	MNS: 5850:2008
6. Ургамлын мониторинг Төрөл зүйлийн тоо ба нэгж талбай дахь нягтаршил	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал
7. Амьтны мониторинг Төрөл зүйл, тоо толгой бай шилжилт хөдөлгөөн	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал
Бүгд			14,000\$	

Хүснэгт 4: Package 2, SW1-2 хэсгийн 2014 оны Мониторингийн ажлын төсөв

Мониторингийн үзүүлэлтүүд	Мониторингийн цэгүүд	Давтамж	Зардал (ам.доллар)	Мөрдөгдөх стандартууд
1. Агаарын чанарын мониторинг, тоосжилт (PM10)	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	290\$ x 3 цэгт x 6 удаа = 5,220\$	MNS:4585-98 MNS:3384 MNS:4048 MNS:5885 : 2008
2. Усны чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Худаг, кэмпийн гал тогоо, голын ус зэрэг 10 цэгээс дээж авах	Сар бүр	330\$ x 3 цэгт x 6 удаа = 5,940 \$	MNS: 3934 MNS: 5667
3. Дуу чимээний хэмжилт, Децибеллээр хэмжигдсэн хамгийн дээд түвшин	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	50\$ x 3 цэгт x 6 удаа = 900 \$	MNS: 0012-1-009:1995
4. Ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал ба эрүүл ахуй	Шаардлагатай бүх цэгүүдэд	Сар бүр	6 удаа - 1,180\$	Эрүүл ахуйн шаардлагууд, Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын журам
5. Хөрсний чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	320\$ x 3 цэгт x 6 удаа = 5,760 \$	MNS: 5850:2008
6. Ургамлын мониторинг Төрөл зүйлийн тоо ба нэгж талбай дахь нягтаршил	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

7. Амьтны мониторинг Төрөл зүйл, тоо толгой бай шилжилт хөдөлгөөн	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал
Бүгд			20,000\$	Мөрдөгдөх стандартууд

Хүснэгт 5: Package 2, SW1-3 хэсгийн 2014 оны Мониторингийн ажлын төсөв

Мониторингийн үзүүлэлтүүд	Мониторингийн цэгүүд	Давтамж	Зардал (ам.доллар)	Мөрдөгдөх стандартууд
1. Агаарын чанарын мониторинг, тоосжилт (PM10)	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	290\$ x 2 цэгтх 6 удаа = 3,480\$	MNS:4585-98 MNS:3384 MNS:4048 MNS:5885 : 2008
2. Усны чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Худаг, кэмпийн гал тогоо, голын ус зэрэг 10 цэгээс дээж авах	Сар бүр	330\$ x 2 цэгт x 6 удаа = 3,960 \$	MNS: 3934 MNS: 5667
3. Дуу чимээний хэмжилт, Децибеллээр хэмжигдсэн хамгийн дээд түвшин	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	50\$ x 2 цэгт x 6 удаа = 600 \$	MNS: 0012-1- 009:1995
4. Ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал ба эрүүл ахуй	Шаардлагатай бүх цэгүүдэд	Сар бүр	6 удаа - 1120\$	Эрүүл ахуйн шаардлагууд, Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын журам
5. Хөрсний чанарын мониторинг Химийн болон хүнд металлын шинжилгээ	Зам дагуу, зуурмагийн цехүүд, кэмпүүд зэрэг 10 цэгт	Сар бүр	320\$ x 2 цэгт x 6 удаа = 3,840 \$	MNS: 5850:2008
6. Ургамлын мониторинг Төрөл зүйлийн тоо ба нэгж талбай дахь нягтаршил	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал
7. Амьтны мониторинг Төрөл зүйл, тоо толгой бай шилжилт хөдөлгөөн	Замын коридор дагуу	Жилд 1 удаа	500\$	Хээрийн судалгааны аргачлал
Total			14,000\$	

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

3.3 Мониторингийн ажлын үр дүн

3.3.1. Хөрсний чанарын мониторинг

Хүснэгт 6: Хөрсний химийн анализ

Дээж авсан цэгийн нэр	Гүн, см	pH _{H₂O} (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Уртын кэмп	0-50	8.35	2.91	0.610	0.103	0.72	9.4
Могойн хар харйганы карьер	0-15	8.19	2.18	1.360	0.257	1.06	11.5
Хужиртын амны карьер	0-15	8.03	1.45	1.969	0.432	1.34	14.2
Бодончийн хавцал	0-15	8.40	2.18	2.707	0.090	1.83	12.4
Цагдуултын гүүрний ойролцоох ухмал	0-15	8.12	0.00	4.479	0.501	2.49	21.7
Package I-ийн Төв Кэмп	0-15	8.24	3.64	0.614	0.145	0.42	6.8
5 Овоогийн ухмал	0-15	8.28	0.00	3.644	0.225	1.37	15.1
Цахирын гол	0-15	8.47	4.73	2.655	4.360	1.83	12.9
Package II-ийн Мааньт кэмп	0-15	8.21	0.00	1.600	0.080	1.24	10.4

Хүснэгт 7: Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж авсан цэгийн нэр	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % (mm)		
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
Уртын кэмп	0-15	67.4	23.9	8.7
Могойн хар харйганы карьер	0-15	65.9	23.4	10.6
Хужиртын амны карьер	0-15	70.3	21.2	8.4
Бодончийн хавцал	0-15	54.2	35.1	10.6

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Цагдуултын гүүрний ойролцоох ухмал	0-15	44.0	44.6	11.4
Package I-ийн Төв Кэмп	0-15	64.5	23.9	11.7
5 Овоогийн ухмал	0-15	57.2	31.9	10.9
Цахирын гол	0-15	54.2	34.5	11.2
Package II-ийн Мааньт кэмп	0-15	64.5	27.8	7.7

Хүснэгт 8: Хөрсний хүнд металлын анализ

№	Дээж авсан цэгийн нэр	Гүн, см	Хүнд металлын агууламж /мг/кг/				
			Cr	Pb	Cd	Ni	Zn
5	Бодончийн хавцал	0-15	131.7	2.8	0.033	203.3	172.3
9	Цахирын гол	0-15	28.0	24.8	0.048	8.6	211.2
	МУ-ын Стандарт (MNS 5850 : 2008)		150	100	3	150	300

Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн төслийн зам дагуух нутаг дэвсгэрийн хөрсөнд хүнд металлын бохирдол байхгүй байна хэмээн дүгнэж болохоор байна. Хүнд металлын шинжилгээнээс үзэхэд, хөрсний дээжин дэхь хүнд металлуудын агууламж хэвийн хэмжээнд байна.

3.3.2 Усны чанарын мониторинг

Хүснэгт 9: Усны химийн шинж чанарын анализ 1

Дээж авсан газрын нэр		Уртын кэмийн гал тогооны ус	Уртын кэмийн худгийн ус	Бодончийн голын ус	Хужиртын кэмийн гал тогооны ус	Нэгж	Ундны усны стандарт (MNS 900:2005)
Үзүүлэлтүү	№	1	2	3	4		
Булингар		Булингаргүй	39.2	Булингаргүй	Булингаргүй	mg/l	1.5

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Эрдэсжилт		886.40	855.02	197.7	359.56	mg/l	1000
Урвал		8.81	8.58	8.56	8.37	pH	6.5-8.5
EC		1.142	1.287	0.244	0.482	dS/m	
Хатуулаг		8.5	8.0	2.2	4.0	mg/l	7.0
CO ₃ ²⁻		6.0	0.0	6.0	3.0	mg/l	
HCO ₃ ⁻		305.0	311.1	115.9	158.6	mg/l	
Cl ⁻		95.8	95.8	14.2	28.4	mg/l	350
SO ₄ ²⁻		215.7	217.3	13.2	70.0	mg/l	500
Ca ²⁺		88.6	85.0	34.1	54.9	mg/l	100
Mg ²⁺		49.0	45.7	5.8	14.8	mg/l	30
Na ⁺		126.3	100.1	6.9	25.1	mg/l	200
K ⁺		2.7	2.7	1.6	4.7	mg/l	

Хүснэгт 10: Усны химийн шинж чанарын анализ 2

Дээж авсан газрын нэр		Бодончийн гүүр	Цахирын гол	Мааньтын кэмп, гал тогооны ус	Нэгж	Ундны усны стандарт (MNS 900:2005)
Үзүүлэлтүүд	№	5	9	10		
Булингар		Булингаргүй	1583.2	Булингаргүй	mg/l	1.5
Эрдэсжилт		243.7	415.33	668.12	mg/l	1000
Урвал		8.41	8.35	8.18	pH	6.5-8.5
EC		0.284	0.488	0.916	dS/m	
Хатуулаг		2.8	4.3	8.5	mg/l	7.0

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

CO ₃ ²⁻		4.5	1.5	1.5	mg/l	
HCO ₃ ⁻		128.1	176.9	158.6	mg/l	
Cl ⁻		21.3	24.8	74.5	mg/l	350
SO ₄ ²⁻		31.3	107.0	228.0	mg/l	500
Ca ²⁺		38.1	46.3	110.6	mg/l	100
Mg ²⁺		10.5	23.8	36.4	mg/l	30
Na ⁺		9.9	35.0	57.0	mg/l	200
K ⁺		2.7	2.0	1.6	mg/l	

Хүснэгт 11: Усны химийн шинж чанарын анализ 3

Дээж авсан газрын нэр		Кэмп 28, худгийн ус	5 Овоогийн карьер, худгийн ус	Package 1 Төв кэмп, гал тогооны ус	Package 2 Төв кэмп, гал тогооны ус	Нэгж	Ундны усны стандарт (MNS 900:2005)
Үзүүлэлтүүд	№						
Булингар		Булингаргүй	Булингаргүй	Булингаргүй	Булингаргүй	mg/l	1.5
Эрдэсжилт		366.9	780.85	615.19	748.28	mg/l	1000
Урвал		8.04	8.03	7.83	7.96	pH	6.5-8.5
ЕС		0.438	1.045	0.797	1.028	dS/m	
Хатуулаг		4.0	9.6	6.6	6.9	mg/l	7.0
CO ₃ ²⁻		0.0	0.0	0.0	0.0	mg/l	
HCO ₃ ⁻		167.7	167.7	146.4	289.7	mg/l	
Cl ⁻		28.4	99.4	53.2	46.1	mg/l	350
SO ₄ ²⁻		74.9	282.4	248.6	241.2	mg/l	500

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

Ca ²⁺		56.1	126.7	45.7	54.1	mg/l	100
Mg ²⁺		14.7	40.3	52.2	50.8	mg/l	30
Na ⁺		25.1	64.4	64.4	64.4	mg/l	200
K ⁺		4.7	1.56	4.72	2.0	mg/l	

Хүснэгт 12: Усны хүнд металлын анализ

Дээж авсан газрын нэр	№	Хүнд металлын агууламж мг/л				
		Cr	Pb	Cd	Ni	Zn
Бодонч голын ус	2	0.000	0.008	0.001	0.02	0.043
Цахирын голын ус	9	0.000	0.01	0.002	0.090	0.240
Ундны усны стандарт (MNS 900:2005)		0.05	0.01	0.003	0.02	5

Мониторингийн багийн гишүүд байгаль орчны хувьд мэдрэг цэгүүд болон кэмпийн ажилчдын цэвэр усан хангамжийн эх үүсвэр болсон гүний худгууд, Төслийн зам дагуух гадаргын усны хамгийн томоохон нөөц болох Бодончийн гол болон Цахирын голын уснаас, мөн кэмпийн эрүүл ахуйн нөхцөлийг баталгаажуулах зорилгоор кэмпүүдийн гал тогооны крантнаас усны дээжүүдийг мөн авч шинжилгээнд хамруулсан.

Бодонч ба Цахирын голын усны дээжнүүдэд аль алинд нь хар тугалга, цайр, кадми, хром, никель зэрэг хамгийн өргөн тохиолддог хүнд металлын агууламж хэвийн хэмжээнээс хэтрээгүй тул тэдгээр голууд нь хүнд металлын бохирдолд өртөөгүй гэж дүгнэхэд болно.

Ажилчдын суурин газруудын ойролцоох гүний худгууд болон кэмпийн гал тогооны уснаас авсан дээжүүдэд ямар нэгэн бохирдол илрээгүй бөгөөд бүх үзүүлэлт нь Монгол Улсын Ундны усны стандартыг хангаж байна. Стандарт шаардлага хангаагүй ганц тохиолдол гарсан нь Уртын кэмпийн ойролцоох гүний худгийн уснаас авсан дээжинд булингарын түвшин хэвийн хэмжээнээс өндөр байв. Харин Уртын кэмпийн гал тогооноос авсан усны дээжид уг үзүүлэлт хэвийн байсан тул эрүүл ахуйн ноцтой нөлөөлөл байхгүй

гэж дүгнэж болохоор байна. Мониторингийн багийн зүгээс Уртын кэмийн ойролцоох гүний худгийн усанд дараагийн удаагийн мониторинг хэмжилтийн явцад илүү анхаарал хандуулан ажиллах болно.

3.3.3 Агаарын чанар: Тоос хэмжилт

Мониторингийн баг нь тоосжилтын түвшин харьцангуй өндөр байж болох ажилчдын суурин, ахмал, карьеруудын ойр орчимд болон зам барилгын ажил идэвхтэй явагдаж буй газруудад 17 цэгийг сонгон хэмжилт хийсэн. Хэмжилтийг цэг бүр дээр 30 минутын турш хийж хэмжилтын хамгийн өндөр, хамгийн бага болон дундаж үр дүнг хэмжсэн болно.

Монгол Улсын Орчны Агаарын Чанарын Стандарт ёсоор агаар дахь тоосны нягтаршил 0.1 мг/м³-ээс хэтрэх ёсгүй юм. Хэмжсэн 17 цэгт нь тоосжилтын түвшин стандарт хэмжээнд байв.

Хүснэгт 13: Мониторингийн цэгүүдэд хэмжигдсэн тоосжилтын түвшин

№.	Хэмжилт хийсэн цэг	Тоосны дундаж агууламж (мг/м ³)	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (мг/м ³)
1	Уртын кэмп	0.097	0.100
2	Могойн хар хайрганы карьер	0.035	
3	Хужиртын амны карьер	0.27	
4	Хужиртын кэмп	0.085	
5	Кэмп 54	0.174	
6	Цагдуултын ам	0.537	
7	Кэмп 28	0.189	
8	Боомын ам	0.847	
9	Package I Төв кэмп	0.551	
10	Package II Төв кэмп	0.067	
11	Мааньт	0.085	

Зураг 13: Ховд аймгийн Ус цаг уурын хүрээлэнгийн мэргэжилтэн тоосны хэмжилт хийж буй нь



3.3.4 Дуу чимээ

Зам барилгын ажлын идэвхтэй цагуудаар хүнд даацын машинууд, тоног төхөөрөмжүүдээс үүсэх дуу чимээний түвшин өндөр байх магадлалтай тул мониторингийн баг нь дуу чимээний түвшин хэмжих цэгүүдийг тоосны хэмжилт хийсэн цэгүүдтэй ижил байхаар тооцоолон сонгосон юм. Монгол Улсын Орчны Агаарын Чанарын Стандартын дагуу ажлын байран дахь дуу чимээний зөвшөөрөгдөх дээд хэмжээ 90 децибеллээс ихгүй байх ёстой юм. Хэмжилт хийгдсэн 17 цэгт дуу чимээний түвшин стандарт хэмжээнээс хэтрээгүй байлаа.

Хүснэгт 14: Мониторингийн цэгүүдэд хэмжигдсэн дуу чимээний түвшин

Но.	Хэмжилт хийсэн цэг	Дуу чимээний түвшин /децибел/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (децибел)
1	Уртын кэмп	68.9	90
2	Могойн хар хайрганы карьер	55.1	
3	Хужиртын амны карьер	67.8	

4	Хужиртын кэмп	58.0
5	Бодончийн гүүр	62.1
6	Бодончийн хавцал	61.3
7	Цагдуултын ам	67.2
8	Кэмп 28	56.5
9	Package 1 Төв кэмп	59.3
10	5 овооны карьер	76.5
11	5 овооны кэмп	56.5
12	Цахирын гол	41.8
13	Package II Мааньтын кэмп	53.9

3.4. Олон нийттэй харилцах ажлууд

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс орон нутгийн иргэдтэй илүү ойр ажиллаж, гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэж байхын тулд Манхан, Мөст, Алтай гэсэн 3 суманд Орон нутгийн мониторингийн зөвлөхүүдийг 2013 оны 7-р сард сонгон сонгон авч, ажиллуулж байна. Орон нутгийн мониторингийн зөвлөхүүд нь орон нутгийн ард иргэдэд төслийн ажлын талаар сургалт, сурталчилгаа хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах, айл өрхүүдээр явж санал асуулгын хуудас бөглүүлэх, зам барилгын ажил идэвхтэй явагдаж буй цэгүүд дээр очиж үзлэг шалгалт хийх, иргэдийн санал гомдлыг хүлээн авч мэдээлэх зэрэг ажлуудыг багтаасан 7 хоног тутмын ажлын төлөвлөгөөтэй ажиллаж байна. Орон нутгийн мониторингийн зөвлөхүүдийн ажлын үр дүнг 2014 оны Олон нийттэй харилцах ажлын тайланд дэлгэрэнгүй авч үзэх болно.

4. ДҮГНЭЛТ

Төслийн зүгээс энэхүү тайлангийн хугацаанд байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ хангалттай сайн түвшинд биелүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Байгаль орчныг хамгаалах ажлууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн нөхцөл шаардлагуудыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэсэний дээр 5,6-р саруудад хөрс, ус, агаарын чанарын мониторингийн ажлуудыг амжилттай хийсэн. Төслийн Гүйцэтгэгч тал Газарзүйн хүрээлэн, Ховд аймгийн

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ТӨСӨЛ

ус цаг уурын хүрээлэн зэрэг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран мониторингийн ажлуудыг хийж гүйцэтгэн, лабораторийн шинжилгээний үр дүнд анализ хийж сар тутмын тайландаа хавсаргасан байна.

Манхан, Мөст, Алтай сумдад ажиллаж буй орон нутгийн мониторингийн зөвлөхүүд нутгийн ард иргэдэд төслийн бүтээн байгуулалт, ажлын явж, байгаль хамгаалах арга хэмжээний талаар сурталчлан таниулах ажлыг 7 хоног бүр хийж, ард иргэдийн цаашдын ажилдаа тусган хэрэгжүүлэх талаар системтэй ажиллаж байна.

Зам барилгын ажил идэвхтэй явагдсанаар тоосжилт, дуу чимээ зэрэг түр зуурын нөлөөллүүд үүссэн боловч Гүйцэтгэгч байгууллагын зүгээс бууруулах арга хэмжээнүүдийг амжилттай авч хэрэгжүүлснээр нөлөөллийг зохих хэмжээнд хүртэл нь багасгаж чадсан.

Цаашдын ажилд анхаарч, хэрэгжүүлэх зүйлс:

1. Гүйцэтгэгч байгууллагын зүгээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн зэрэглэлийг тодорхойлох сар тутмын мониторингийн ажлуудаа үргэлжлүүлэн хийж, тухайн сарын ажлын тайланг дараа сарын 10-ны дотор бэлтгэн өгч байх. Ингэснээр Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс сар тутмын мониторингийн үр дүнд шинжилгээ хийж, байгаль орчинд эрсдэл учруулахуйц үр дүн гарсан тохиолдолд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ цаг алдалгүй төлөвлөж явахад тустай юм.
2. Усны чанарын болон Ан амьтны шилжилт хөдөлгөөний мониторингийн бие даасан зөвлөхүүд сонгогдон ажлаа эхлэх бөгөөд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс тэдгээр зөвлөхүүдийн ажлын гүйцэтгэл гэрээний дагуу, төлөвлөсөн цаг хугацаандаа явагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах болно. Ан амьтны шилжилт хөдөлгөөний судалгааны эцсийн тайлан нь ан амьтад болон нүүдлийн мал сүргийн Төслийн замыг хөндлөн гарах цэгүүдийг тодорхойлж өгөх судалгааны гол бичиг баримт болох юм. Харин усны чанарын мониторингийн судалгааны эцсийн тайлан нь Төслийн бүс нутгийн гадаргын болон гүний усанд бохирдол, нөлөөлөл байгаа эсэхийг нарийвчлан үзүүлсэн чухал баримт бичиг болох юм.
3. Бодонч, Цахирын гол дээгүүр баригдаж буй гүүрнүүдийн ойр орчмын газруудад илүү нарийвчилсан, өргөн хүрээний мониторинг хийх шаардлагатай юм. Голын усан дахь түр зуурын булингаржилтыг хянаж, ойр орчмын малчин айлуудад мэдээлж ажиллах тал дээр Гүйцэтгэгчийн зүгээс илүү анхаарах шаардлагатай. Гол руу тос болон бусад барилгын материал урсаж орохоос сэргийлсэн арга хэмжээгээ

үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнг нь сар тутмын тайландаа тусгаж өгч байх шаардлагатай.

4. Төслийн замын Package 1 хэсэг нь энэ жил дуусах төлөвлөгөөтэй ажиллаж буй тул зам дагуу ашиглагдаж буй ухмал болон хайрганы карьеруудыг нөхөн сэргээхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

